



2024 оны 5 сарын 28

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАРИМТ БИЧИГ

SFA CASHMERE STANDARD



УДИРТГАЛ

Баримт бичгийн зорилго

Энэхүү баримт бичиг нь [олон нийтийн хэлэлцүүлэг](#) зориулан гаргасан SFA Cashmere Standard v2.0 (цаашид Стандарт гэх) стандартын төслийн агуулгад нийцсэн нэн чухал бодлогын баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь стандартыг шинэчлэх шаардлагын зарим мэдээлэл, санал болгож буй засварын хураангуйг агуулсан болно.

Хэлэлцүүлгийн зорилго

SFA-ийн хэлэлцүүлгийн зорилго нь жинхэнэ, шударга, хүртээмжтэй байх, стратегийн ойлголтыг баталгаажуулах, зөвшилцөл, итгэлцлийг бий болгох явдал юм. Бидний үндсэн зарчим бол хэлэлцүүлгүүд нь SFA-д зорилгодоо хүрэхэд дэмжлэг болох бөгөөд оролцогчдод тэдний санал бодлыг хэрхэн авч үзэж буйг олж харахад тустай. Үүнд хүрэхийн тулд ТННЭ нь [SFA-ийн стандарт тохируулах журам](#) -ын хүрээнд [Олон улсын нийгэм, байгаль орчны итгэмжлэл ба тэмдэгтийн байгууллага \(ISEAL\)-ын Стандарт хөгжүүлэх сайн туршагын зохистой дадал](#) -ын дагуу хэлэлцүүлгийг зохион байгуулахыг эрмэлзэж байгаа болно.

ISEAL нь бүх оролцогч талуудын оролцоо нээлттэй байхыг шаарддаг бөгөөд стандарт хөгжүүлэгчээс нийгэмд дуу хоолойгоо хүргэхэд хүндрэлтэй тулгардаг тэдгээр талуудын хувь нэмрийг идэвхтэй эрэлхийлэхийг шаарддаг. Энэ нь стандартад саналаа оруулагчид нь тухайн стандартын хэрэглэгдэх газарзүйн хүрээ болон ялгаатай ашиг сонирхлуудыг төлөөлж буй эсэхийг баталгаажуулах явдал юм.



**CLICK HERE TO
GET CERTIFIED NOW**

ЯАГААД СТАНДАРТЫГ ХЯНАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

ҮНДСЭН ойлголт

SFA Cashmere Standard нь дэлхийн баталгаажсан ноолуурын зах зээлд хамгийн том хувийг эзэлдэг. Энэхүү стандарт нь үр дүнтэй удирдлагын тогтолцоо, баталгаатай мөшгөх тогтолцоогоор дамжуулан ямааны тавлаг байдлыг сайжруулах, биологийн олон янз байдал болон бэлчээр, газар нутгийг хамгаалах, зохистой хөдөлмөрийг дэмжих, ширхэгтийн чанарыг сайжруулахад чиглэсэн ноолуурын цорын ганц стандарт юм. Стандарт нь малчдын харилцаа, өв уламжлалын онцлог байдлаар дамжуулан ноолуур үйлдвэрлэгч малчдид, малдын байгууллагын дуу хоолойг жинхэнэ утгаар нь илэрхийлэх шаардлагатай.

Хувилбар 1.0 нь 2022 оны түрш өргөн хүрээтэй хянан засварлаж, олон талт хэлэлцүүлэг өрнүүлсний үр дүнд 2023 оны 1-р сард хэвлэгдсэн. Та Хувилбар 1.0-ийн хөгжүүлэлт болон хүлээн авсан санал хүсэлтийн талаарх дэлгэрэнгүйг [энд](#)ээс үзэж болно. Гэхдээ уг засвар нь юуны түрүүнд үндэсний түвшний стандартыг дэлхийн түвшний стандарт болгон хөгжүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлт болон ширхэгтийн чанарыг сайжруулахтай холбоотой шаардлагуудыг стандартад нэмж оруулахтай холбоотойгоор хийгдэж байсан.

Ямар нэг асуудлын талаарх байнгын маргаан

Стандартыг хэлэлцүүлснээс хойш зарим оролцогч талуудын зүгээс амьтдын тавлаг байдлын шалгуур үзүүлэлтүүд нь өөрчлөгдөн буй хэрэглэгчдийн хүлээлтийг хангахгүй байж магадгүй гэх болгоомжлолыг дэвшүүлсэн. Энэ нь ISEAL-ын Стандарт хөгжүүлэх сайн туршлагын зохистой дадлын 6.5-д заасан "Бодит, шийдэгдээгүй асуудлууд хэвээр байгаа тохиолдолд [...] схем эзэмшигч шаардлагатай бол нэмэлт олон нийтийн болон/эсвэл зорилтот бүлгийн хэлэлцүүлгүүдийг явуулна." гэсэн шаардлагыг биелүүлэх нөхцөл болов.

Цаашид

Үүний дагуу SFA нь SFA Cashmere Standard v1.0-д шилжих шилжилтийн эцсийн хугацааг цаашдын хөгжүүлэлтийн ажил хийгдэж дуустал хойшлуулсан. Олон нийтэд хэлэлцүүлэхээр [энд](#) танилцуулсан Стандартын төсөл бол тэрхүү ажлын үр дүн юм. Энэхүү хэлэлцүүлгийн дараа SFA нь хүлээн авсан санал хүсэлтүүдийг хянан үзэж SFA Cashmere Standard v2.0-ийн эцсийн хувилбарыг боловсруулах бөгөөд эцсийн хувилбар нь 2024 оны 12-р сард нийтлэгдэх болно. Энэхүү стандартаас бусад буюу SFA-ийн хөтөлбөртэй холбоотой бусад асуудал, санал хүсэлтийг [SFA Нээлттэй хэлэлцүүлгийн хуудсаар \(SFA Open Consultation Portal\)](#) дамжуулан илгээнэ үү.

ТӨСӨЛ БУЮУ САНАЛ

Энэхүү хэлэлцүүлэгт танилцуулсан Стандартын төсөл нь SFA Cashmere Standard v1.0 болон түүний өмнөх бүх хувилбаруудыг орлох болно. Энэ хэсэгт энэхүү стандартын төсөл нь SFA Cashmere Standard v1.0-ээс юугаараа ялгаатай болохыг тоймлон танилцуулав. Стандартын төсөл хэрхэн бүтнээр хэрэгжих талаар дэлгэрэнгүй мэдээллийг [SFA Нээлттэй хэлэлцүүлгийн хуудсаар](#) дамжуулан Стандартын төслөөс олж мэдэх боломжтой.

ТӨСЛИЙН ТОЙМ

Ямааг нядалгааны зорилгоор борлуулахтай холбоотой шинэ Шалгуур үзүүлэлт(үүд)

Зарим оролцогч талуудаас амьтдын тавлаг байдлын шалгуур үзүүлэлтүүд нь өөрчлөгдөн буй хэрэглэгчдийн хүлээлтийг хангахгүй байж магадгүй гэх болгоомжлолыг дэвшүүлсэн. Эдгээрт 'SFA Certified' буюу баталгаажсан малчны байгууллагаас ямааг ямар нэг хуулийн зохицуулалтгүй нядалгааны газруудад худалдахтай холбоотой асуудал багтсан. Нядалгааны газруудыг баталгаажуулах нь SFA-ийн стандартын цар хүрээний гадуур байдаг ч бид "SFA Certified" ноолуур бий болгосон бүх ямааны амьдралын төгсгөл хүртэл нь тодорхой хариуцлага хүлээх ёстой гэж бид үзэж байна. Баталгаажсан малчны байгууллагуудын малыг хүлээн авч буй нядалгааны газруудад тодорхой хэмжээнд нөлөөлөхийн тулд бид баталгаажсан аж ахуйн нэгж буюу малчны байгууллагуудыг нядалгааны газартай хууль ёсны хүчинтэй гэрээ байгуулах, хяналт шалгалтын шаардлагыг санал болгож байна. Энэхүү гэрээнд нядалгааны газар нь SFA-ийн стандартын малын тавлаг байдлын хэсгийг дагаж мөрдөх нөхцөл тавих бөгөөд баталгаажсан байгууллагын холбогдох ажиглагчдад (жишээ нь Тохирлын үнэлгээний байгууллага, цаашид ТҮБ гэх) үүнтэй ТАНИЛЦАХ, нэвтрэх боломжийг олгох ёстой.

Санал болгож буй шинэ шаардлага нь 18.4-т байгаа бөгөөд үүний тайлбарыг доор дурдсан болно:

- 18.1 *Малчин (мал нядалгааны газар) нь ямааг төхөөрөхийн өмнө богино хугацаанд ухаан балартуулах, нядалгааны явцад мэдээ/ухаан орж, сэргэхээргүй байх ухаан алдуулах аргыг **ашиглана**.*
-  Энэхүү шалгуур үзүүлэлтийн зорилго нь ямааны өвдөлт зовиур, айдсыг багасгахад оршино.
- 18.2 *Малчин (мал нядалгааны газар) нь ямааг зөвхөн цэвэрхэн, зориулалтын багажаар, дадлага туршлагатай хүнээр **төхөөрүүлэнэ**.*
- 18.3 *Малчин (мал нядалгааны газар) нь ямааг нядалгааны зорилгоор амьдаар нь олон улсын худалдаанд **борлуулахгүй**.*
- 18.4 *Малчин нь ямааг нядалгааны зориулалтаар худалдаалахдаа худалдан авч буй талтай, дараах үүргүүдийг нядалгааны газар нь биелүүлэх шаардлагатай болохыг тусгасан бичгэн гэрээ **хийнэ**:*
- a) *энэхүү стандартын 18.1, 18.2, 18.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэх;*
 - b) *Нядалгааны газар нь малчдын байгууллага, малчин, ТННЭ эсвэл ТҮБ-аас ирүүлсэн хүсэлтэд үндэслэн тухайн малчны ямааг нядалсан цэгүүд, үүнтэй холбоотой бүх төрлийн дата, мэдээлэлд ямар нэг хязгаарлалт, хориглолтгүйгээр бүрэн*



*хандах, нядалгаа хийхэд оролцсон бүх ажилтантай ганцаарчилж уулзах
боломжийг малчны байгууллага болон ТҮБ-д олгох.*

Тасралтгүй сайжруулалтын онооны механизмыг шинэчилсэн

Ноолуур үйлдвэрлэлийг баталгаажуулж байсан өмнөх SFA-ийн зохистой дадлуудаар оноо өгөхдөө медалийн (алт, мөнгө, хүрэл) системийг дагаж мөрддөг байсан. Эдгээр зохистой дадлуудыг SFA Cashmere Standard-д нэгтгэхдээ, малчны байгууллагууд нь баталгаажуулалтын бүх шалгуур үзүүлэлтүүдийг хангах шаардлага бүхий шинэ тэнцсэн/тэнцээгүй системийг нэвтрүүлсэн. Энэ нь баталгаажих босгыг нэлээд дээшлүүлж, баталгаажилт авч байсан зарим аж ахуйн нэгжийг баталгаажилтаас хасч болзошгүй юм. Шинэчилсэн стандартын төсөл нь малчдын байгууллагаас хүлээгдэж буй хамгийн бага гүйцэтгэлийг (өөрөөр хэлбэл, "малчны байгууллага/малчин" нь ... ёстой, -на" гэж тодорхойлогдсон бүх шалгуур үзүүлэлтүүд) илүү тодорхой болгох зорилготой бөгөөд үүнд "байнгын сайжруулалтыг" харуулах шалгуур үзүүлэлтүүдийг ч багтаасан болно. Стандартын v1.0 хувилбарын зарим шаардлагуудыг энэхүү шинэчилсэн хувилбарт "сайжруулах үзүүлэлт" гэж тодорхой тодорхойлсон (өөрөөр хэлбэл "[малчны байгууллага/малчин] ... -ж болно" гэж тодорхойлсон); эдгээрийг малчны байгууллага нь "байнгын сайжруулалтыг" хийж буйгаа бататган харуулахын тулд хэрэгжүүлэхээр сонгож болно.

Малчны байгууллага нь эдгээр бүх сайжруулах үзүүлэлтүүдийг хангасны дараа тэд тасралтгүй сайжруулалт хийхээс чөлөөлөгдөж, өндөр гүйцэтгэлтэй малчны байгууллагуудад олгогдох "SFA шилдэг түршлага"-ыг хангасан гэх нэр хүндтэй мэдэгдэл гаргах боломжтой болно. Түүнчлэн, эдгээр сайжруулалтын үзүүлэлтүүдийн заримыг зөвхөн орон нутаг дахь мал аж ахуйн системд (жишээ нь боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа биш) гүйцэтгэх боломжтой бөгөөд энэ нь SFA-аас хамгийн их дэмжиж буй ноолуур бэлтгэл/үйлдвэрлэлийн шилдэг гэх тодотголыг хадгална гэсэн үг юм.

Стандарт дахь сайжруулах үзүүлэлтүүдийг хялбар танихын тулд "-ж болно" гэж тодорхойлсоноор нь таних боломжтой.

Газрын эрхийн баталгааны шинэ үзүүлэлт

SFA Cashmere Standard v2.0 нь малчид тухайн газар мал маллах, мал аж ахуйн үйл ажиллагаа явуулах хууль ёсны эрхтэй гэдгээ батлах шинэ шаардлагыг багтаасан.

8.1 *Малчид нь ашиглаж буй газраа хууль ёсны дагуу эзэмших/ашиглах/өмчлөх зөвшөөрөлтэй гэдгээ батлан харуулах ёстой.*

Мал төхөөрөхтэй холбоотой хязгаарласан шалгуур үзүүлэлтийг хасав

SFA Cashmere Standard v1.0 хувилбарт дараах шаардлага багтсан байсан: *Ямааг зөвхөн удаан хугацаанд өвдөлт мэдэрч байгаа эвсэл өвчтэй байгаа, эдгэрэх найдваргүй, эмчилгээ хийсэн ч сэргэхгүй байгаа, өвчин нь архаг буюу хүнд хэлбэрт шилжсэн байгаа тохиолдлуудад төхөөрөх ёстой.* Бид энэ шаардлагыг үндэслэлгүй гэж үзэн хассан. Учир нь хувийн хэрэгцээнд зориулан нядалгаа эсвэл худалдан борлуулах нь мал аж ахуйн зайлшгүй хэсэг, ялангуяа бие даасан жижиг нэгж (малчин өрх)-ийн хувьд зайлшгүй чухал хэсэг юм.

Өрхийн хэрэгцээнд төхөөрөх ямааны чанартай холбоотой шалгуур үзүүлэлтийг хасав

SFA Cashmere Standard v1.0 хувилбарт дараах шаардлага багтсан байсан: *Малыг хүнсний зориулалтаар төхөөрөхөөс өмнө малд хэрэглэсэн эмийн үйлдвэрлэгчийн зааварчилгааг дагах ёстой бөгөөд ямааны биед эм болон тарианы үлдэгдэл байхгүй болсон байна.* Энэ нь

SFA ноолуурын стандартын цар хүрээнд хамаарахгүй тул бид энэ шаардлагыг хассан. Энэ нь Стандартын таван зарчмын (биологийн олон янз байдал ба газар ашиглалт, зохистой хөдөлмөр эрхлэлт, малын тавлаг байдал, үр дүнтэй удирдлага зохион байгуулалт, ширхэгтийн чанарыг сайжруулах) аль нэгэнд хамаарахгүй.

Малчны байгууллагыг тодорхойлсон шинэ үзүүлэлтүүд

Бид малчны байгууллага болон түүний гишүүн малчдыг тодорхойлох шинэ шаардлагуудыг оруулсан. Энэ нь [ТННЭ-ийн үнэлгээ, баталгаажуулалтын гарын авлагын v1.1](#)-ийн 28-р хэсэгт өгүүлсэнчлэн хэн баталгаажилтад хамрагдах ётойг, мөн малчны байгууллагууд болон тэдгээрийн гишүүн малчин өрхүүд хэрхэн нэгдмэл байдлаар (хамтдаа) стандартад тэнцэх эсвэл тэнцэхгүйг харуулсан.

Ажилчдын үр чадвар

SFA Cashmere Standard v1.0-ийн олон шаардлага нь вакцинжуулалт, мал хөнгөлөх гэх мэт эмнэл зүйн холбогдолтой арга хэмжээг малын эмчийн зөвлөгөөний дагуу хийх ёстой гэсэн шаардлагыг агуулж байсан. Бид эдгээр шаардлагуудын ихэнхийг сайжруулах үзүүлэлт болгон өөрчилсөн хэдий ч эм үйлдвэрлэгчийн зааврыг дагаж мөрдөхийг зайлшгүй шаардлага болгосон. Малчид үүнийг дагаж мөрдөх нь илүү боломжтой гэж бид үзэж байгаа бөгөөд SFA нь эдгээр үйл ажиллагааны явцад ямааны тавлаг байдлыг хангахыг шаардсан хэвээр байна.

Малчны байгууллага болон малчны тодорхойлолтыг нарийвчлав

SFA Cashmere Standard-ийн гэрчилгээг Тохирлын гэрчилгээгээр илэрхийлдэг бөгөөд энэ нь тухайн гэрчилгээнд хамаарагдах үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлдог. Тохирлын гэрчилгээг ноолуур үйлдвэрлэх чиг үүрэгтэй хэд хэдэн малчин өрх бүхий малчны байгууллага эсвэл ноолуур худалдан авагч аж ахуйн нэгж эзэмшинэ. Аж ахуйн нэгж болох малчны байгууллага болон түүний гишүүн өрхүүд нь өөр өөр тусдаа нэгжүүд хэдий ч Тохирлын гэрчилгээ нь тэднийг баталгаажуулалтын өмнө хамтын үүрэгтэй болгодог. Тиймээс малчны байгууллага болон гишүүн малчид нь стандартын хэрэгжилтэд хамтаараа тэнцэх эсвэл тэнцэхгүй гэсэн үг. Жишээлбэл, хэрэв нэг малчин өрхөд Стандартын үл тохирол илэрвэл энэ нь тухайн малчны байгууллагын бүх малчин өрхүүдэд тус үл тохирол хамааралтай болно.

Гэрчилгээ болон үл тохирлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [ТННЭ-ийн үнэлгээ, баталгаажуулалтын гарын авлагаас](#) авна уу.

Зарим малчдыг хамааралгүй шаардлагуудаас чөлөөлөх

Зохистой хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зарим шаардлагуудыг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг илүүтэй харгалзан боловсруулсан болно. Тиймээс ажил олгогч, ажилтны хоорондын хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилготой ч, малчин өрхийн өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй зарим шаардлагуудад (гэхдээ бүгдийг нь биш) нөхцөлт чөлөөлөлтийг тавьсан. Үүний дагуу мал аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч хүмүүс нь бүгд нэг гэр бүлийн гишүүд байгаа тохиолдолд зарим шаардлагаас чөлөөлөгдөнө.

Стандартад малчин өрх чөлөөлөгдөх заалтуудыг хялбархан олохын тулд "өрхүүд" гэж тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдийг хайна уу.

Малчны байгууллага болон малчны үүргийг тодотгов

Шаардлага болон сайжруулах үзүүлэлт бүр дээр тухайн шаардлагыг хангах үүрэгтэй этгээд нь малчдын байгууллага уу эсвэл малчин өрх үү гэдгийг тодорхой заасан. Энэ нь тухайн шаардлагыг хэрэгжүүлэхэд давхардсан үүрэг, хүчин чармайлтыг арилгахын зэрэгцээ илүү хариуцлагатай байдлыг бий болгоно гэж итгэж байна.

Илүүдэл заалтуудыг арилгах замаар хялбарчлав

Давхардсан болон илүүдэл шаардлагууд нь аудитын төлбөрийг нэмэгдүүлж, гэрчилгээ эзэмшигчдэд төвөгтэй байдлыг үүсгэж болзошгүй. SFA энэхүү шинэчлэлийг Стандартыг оновчтой болгох боломж болгон авч үзсэн.

Жишээлбэл:

- Аюултай материалын ашиглалт ба устгал. Холбогдох заалтууд нь 5 болон 22-р хэсэг болон 6.1.a, 13.2, 13.3 дахь заалтуудад байгаа.

- Усны нөөцийн хамгаалал. Холбогдох үзүүлэлтүүд нь 12.3, 12.4, 12.5 дахь заалтуудад байгаа.
- Газрын эрх. Холбогдох үзүүлэлтүүд нь 8-р хэсэг болон 6.1 (g) заалтад байгаа.
- Тасралтгүй сайжруулалт. Холбогдох үзүүлэлтүүд нь 7-р хэсэгт байгаа.

Нарийвчлал, ойлгомжгүй хэллэгийг арилгав

Стандартын зарим шаардлагууд нь тодорхойгүй ба/эсвэл салаа утгатай байсан. Эдгээр төрлийн шаардлага нь ялгаатай үнэлгээний үр дүнд хүргэж болох бөгөөд өөр өөр ТҮБ-р үнэлгээнд орсон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг өөр өөр малчдын байгууллагууд ялгаатай үнэлгээний дүгнэлтийг авах нөхцлийг үүсгэж болзошгүй. Иймд, бид энэ боломжийг ашиглан ойлгомжгүй үг хэллэгийг арилгаж, бүх шаардлагыг илүү тодорхой илэрхийлэх зорилго тавьсан.

Жишээлбэл

- Мэдлэг, ойлголтын холбогдох шалгуурыг Сургалтын шалгуур үзүүлэлтүүдрүү. Холбогдох заалтууд нь 4-р хэсэгт байгаа.
- Бүртгэл хөтлөлт. Холбогдох заалтууд нь 6-р хэсэгт байгаа.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон бусад НҮБ-ийн байгууллагуудын гаргасан тодорхойлолтууд

Улс орны удирдамжийн шинэ загвар

Энэ стандартыг дэлхийн хэмжээнд хэрэглэхээр төлөвлөж байгаа бөгөөд аль ч улсад ямар ч аж ахуйн нэгжид нэг ижил үндсэн шаардлагууд тавигдана. Гэсэн хэдий ч орон нутгийн нөхцөл байдал нь бодит байдалдаа шаардлага хэрхэн хэрэгжих вэ гэдэгт нөлөөлж болох тул SFA нь "Улс орны удирдамж"-ын загварыг бий болгосон. Энэ нь тухайн улсад стандартын тавигдах шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар аж ахуйн нэгжүүд болон ТҮБ-үүдэд удирдамж өгөх, нэмэлт баримт бичиг юм. Афганистан, Хятад, Монголын улс орны удирдамжийг шинэчилсэн стандарттай зэрэгцүүлэн гаргах бөгөөд дараа нь бусдыг нь нийтлэх болно. Улс орны удирдамжид багтсан сэдвүүдийн жишээ:

- Дэд бүтцийн хүртээмжтэй байдал, жишээлбэл үндны ус, цахилгаан, интернэт гэх мэт;
- Тухайн газрын экологийн онцлог, жишээлбэл ховордсон болон харь зүйлийн амьтан, ургамал;
- Технологи, эм тариа, ноолуур самнах/хяргах төхөөрөмжүүдийн олдоц, хүртээмжтэй байдал;
- Нутгийн иргэд, анхаарах нийгмийн бүлгүүд, жишээлбэл уугуул иргэд;
- Бэлчээрийн менежментийг хэн хариуцдаг болохыг тодорхойлох;
- Тухайн улсад түгээмэл тохиолддог аливаа эрсдэл.

Мөшгөлтийн тогтолцооны стандарттай уялдуулав

SFA Мөшгөлтийн тогтолцооны стандартыг хянаж, шинэ хувилбарыг 2024 оны 4-р сарын 1-нд нийтэлсэн. Энэхүү шинэчлэлттэй холбоотой хийсэн өөрчлөлтүүдийн хураангуйг эндээс харж болно. Энд хамгийн чухал холбогдол нь ноолуур үйлдвэрлэгч/бэлтгэгч малчны байгууллагууд өөрсдийн үйлдвэрлэдэг "SFA Certified" ноолуурыг хэрхэн хянаж, худалдаалах вэ гэдгийг тодорхой тусгасан явдал юм. Энэ нь SFA Cashmere Standard-ийн дагуу баталгаажихыг хүссэн малчны байгууллагууд (болон тэдгээрийн гишүүн малчид) нь SFA Мөшгөлтийн тогтолцооны стандартын дагуу мөн адил баталгаажуулсан байх ёстой гэсэн үг юм. Энэ нь ханган нийлүүлэлтийн сүлжээнд ноолуур бүтээгч/үйлдвэрлэгчдэд нэмэлт хяналт бий болсон гэсэн үг юм.

Дэлгэрэнгүй мэдээлэл: [SFA's Мөшгөлтийн тогтолцооны гарын авлага \(sustainablefibre.org\)](https://sustainablefibre.org)

Стандарт нь тухайн улсын хуулиудтай хэрхэн уялдахыг тодотгосон

Стандарт нь тухайн улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд орон нутгийн хуулийг давуу эрхтэй болгоно гэсэн чөлөөлөлтийг (1.2) багтаасан болно.

Шинэ стандартад шилжих хугацаа

SFA-ийн Тохирлын гэрчилгээ эзэмшигчдэд "SFA Certified" ноолуур бэлтгэлдээ мөрдөх шинэ стандартад шилжих хангалттай хугацаа олгоно. Стандартын хуучин хувилбарууд буюу зохистой дадлуудын дагуу тохирлын гэрчилгээг 2025 оны 4-р сарын 1 хүртэл олгож болно. Энэ өдрөөс өмнө олгосон тохирлын гэрчилгээ дээрх хүчинтэй хугацаа нь дуустал хүчин төгөлдөр байх бөгөөд үүний дараа тухайн байгууллага шинэ SFA Cashmere Standard v2.0. стандартын дагуу баталгаажилт авах шаардлагатай болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг SFA Cashmere Standard v2.0-ийн Хүчин төгөлдөр мөрдөгдөх огнооны хэсгээс авах боломжтой.

Юу өөрчлөгдөөгүй вэ

SFA Cashmere Standard v2.0-ийн хамрах хүрээ нь дэлхийн хэмжээнд хэвээр байгаа бөгөөд үр дүнтэй удридлага зохион байгуулалт, зохистой хөдөлмөр эрхлэлт, биологийн олон янз байдал, малын тавлаг байдлыг сайжруулах, ширхэгтийн чанарыг сайжруулахад чиглэсэн хэвээр байна.

